



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/65

Бат-Өлзий сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох, тендер
амжилтгүй болгох тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, “2023 оны төсөв батлах тухай” сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Үнэлгээний хорооны 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийг үндэслэн Иргэдэд төрийн үйлчилгээг багцаар нь хүргэх боломжийг бүрдүүлэх стандартад нийцсэн тоног төхөөрөмж худалдан авах тендерийн 2 дугаар багц Нэг цэгийн үйлчилгээний өрөөнд тавилга, эд хогшил худалдан авах ажлыг “Гурванхэц булаг” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. Тендерт шалгарсан “Гурванхэц булаг” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Зардалд шаардагдах 15,959,600 (арван таван сая есөн зуун тавин есөн мянга зургаан зуу) төгрөгийг гэрээний дагуу, Орон нутгийн хөгжлийн сангийн бусад хөрөнгө данснаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

4. Иргэдэд төрийн үйлчилгээг багцаар нь хүргэх боломжийг бүрдүүлэх стандартад нийцсэн тоног төхөөрөмж худалдан авах тендерийн багц-1-д нэг аж ахуйн нэгж тендерийн материал ирүүлээгүй тул тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

622301133